



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 585

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13 нэрийн нийт 22,970,628.85 (хорин хоёр сая есөн зуун далан мянга зургаан зуун хорин найман төгрөг наян таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001448

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
57 дугаар тогтоолын хавсралт

**"ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ,
					(төгрөг)	
1	VPN-сувгийн холболт үүсгэх тоног төхөөрөмж-Дархан	2012-06-30	ширхэг	1.00	7,450,500.00	7,450,500.00
2	Тогтмол гүйдлийн хөрвүүлэгч / Current loop conveter w. amplifier/	2013-10-25	ширхэг	1.00	204,533.23	204,533.23
3	Тогтмол гүйдлийн хөрвүүлэгч /Current Loop converter w.amplifier/	2013-10-25	ширхэг	1.00	204,533.23	204,533.23
4	10A тэжээлийн блок / Meanwell PS220A/24VDC/	2013-11-30	ширхэг	1.00	918,300.23	918,300.23
5	2 A тэжээлийн блок / meanwell PS24 DC/12VDC/	2013-11-30	ширхэг	1.00	49,025.17	49,025.17
6	Тогтмол гүйдлийн хөрвүүлэгч /Current loop converter w.amplifier/	2013-10-27	ширхэг	1.00	204,533.23	204,533.23
7	RS-485 Давтагч	2013-11-30	ширхэг	1.00	420,000.00	420,000.00
8	RS-485 Давтагч	2013-11-30	ширхэг	1.00	420,000.00	420,000.00
9	RS-485/RS-232 Хувиргагч	2013-11-30	ширхэг	1.00	360,000.00	360,000.00
10	Проетор	2003-06-30	ширхэг	1.00	2,718,700.00	2,718,700.00
11	Шилэн кабелийн хөрвүүлэгч V-12 /Bro wayC1075c5600/	2005-11-07	ширхэг	4.00	795,600.00	3,182,400.00
12	48 В-ын тэжээлийн системийн аккумулятор	2007-12-31	ком	1.00	3,419,051.88	3,419,051.88
13	48 В-ын тэжээлийн системийн аккумулятор	2007-12-31	ком	1.00	3,419,051.88	3,419,051.88
НИЙТ ДҮН						22,970,628.85
						(хорин хоёр сая есөн зуун далан мянга зургаан зуун хорин найман төгрөг наян таван мөнгө)